



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 278

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай


Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2006-2007 оны хичээлийн жилээс Бэлтрэгийн Цогбадрахыг АНУ-ын Калифорнийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын, Загаржавын Баянаулыг АНУ-ын Вашингтон DC-ийн Олон Улсын хэлний дээд сургуулийн магистрантурт соёл, урлагийн удирдлагын, Шагдарсүрэнгийн Очирхүүг АНУ-ын DeVry-ийн их сургуулийн магистрантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Бэлтрэгийн Цогбадрах, Загаржавын Баянзул нарын сургалтын төлбөрийг хэлний бэлтгэл дуусан тус сургуулийн үндсэн ангид суралцах үеэс эхлэн олгохыг Сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэн-д даалгасугай.

3. Б.Цогбадрах, З.Баянзул, Ш.Очирхүү нарын магистрын судалгааны ажлын чиглэлийг нарийвчлан тохирч, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газрын дарга Ц.Даваасүрэн, Соёл, урлагийн газрын дарга Н.Батмөнх, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Л.Цэдэвсүрэн нарт тус тус үүрэг болгосугай.

4. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус дээлгасугай.



СЛАЙД

Ө.ЭНХТҮВШИН